



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2022 оны 03 дугаар сарын 28

Байгууллагын нэр:

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Нэгжийн нэр:

Шуурхай үйлчилгээний алба

Албан тушаалын нэр:

Цахилгаанчин

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

БЗД, 1-р хороо, Залуучуудын гудамж

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цахилгааны ажлын зураг унших, ашиглах, цахилгааны үзлэг шалгалт хийх, гэмтлийг оношлох, түргэн шуурхай засварлах

Албан тушаалын зорилт:

- 1.Өдөр тутмын ажлын бэлтгэлийг хангах
- 2.Хэлтэс алба нэгжээс ирүүлсэн дуудлагын дагуу цахилгааны үзлэг шалгалт хийх, гэмтлийг оношлох, засвар үйлчилгээг хийх
- 3.Цахилгааны ажлын зураг унших, ашиглах, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар заавар зөвлөгөө өгөх
- 4.Эрхэлсэн ажлын хүрээнд хууль, тогтоомж, холбогдох стандартуудыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, хариуцан гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Ажил эхлэхээс 20 минутын өмнө ирж, ажлын хувцсаа сольж өмсөн, багаж хэрэгслээ бүртгэн, бүрэн бүтэн байдлыг шалгаж ажилд гарах бэлтгэлээ хангах	Цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх	Г
	1.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчлага авч, гарын үсэг зурж баталгаажуулах	Аюулгүй ажиллагааны заавар, шаардлагыг биелүүлж ажиллах	Г
	2.1.Цахилгааны ажлын зураг унших, ашиглах, гэмтэл саатлыг оношлох, засварлах	Цахилгааны үзлэг шалгалтыг хийж, гэмтлийг оношлон,	Г

2 дугаар зорилтын хүрээнд	2.2.Хэлтэс албадууд, авто баазаас ирүүлсэн дуудлагын дагуу газар нь дээр нь очиж цахилгааны үзлэг шалгалт хийх, гэмтлийг оношлон, засвар үйлчилгээ хийх	засвар үйлчилгээг шуурхай хийсэн байх	Г
	2.3.Ажлын хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангуулах, картаар хүлээж авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллах	Заавар, журмыг биелүүлж ажиллах	Г
	2.4.Ажилдаа бүрэн бүтэн багаж хэрэгсэл хэрэглэж, ажил дууссаны дараа багаж хэрэгслээ цэвэрлэн хурааж, хайрцаг саванд хийж тавих	Эмх цэгцтэй, дэг журамтай ажиллах	Г
	2.5.Хийсэн ажлын тэмдэглэл хөтлөх, шаардлагатай тохиолдолд зураг авч баталгаажуулах	Тайлан, мэдээ, бүртгэл судалгааны баримт бүрдүүлэх	Г
	2.6.Хотын гудамж талбайд суурьлуулсан хайс хашлага, сандал, хогийн сав, усан оргилуур, тамхины цэг, нийтийн бие засах газрын засвар, газраас зохион байгуулан хийж байгаа цас цэвэрлэгээ хальтиргаа гулгааг арилгах, ариутгал халдваргүйтгэл зэрэг ажлуудад оролцох	Идэвх санаачлагатай ажиллах	Т
	2.7.Бичил тохижилт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажилд шавар зуурах, элс цемент зөөх, ачиж буулгах, хадах, зэргээр өөрийн хийж чадах ажлуудыг гүйцэтгэх	Идэвх санаачлагатай ажиллах	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Цахилгааны тоног төхөөрөмж, тоноглолын засвар үйлчилгээг чанартай хийж, найдвартай ажиллагааг хангах	Ажлын гүйцэтгэл үр дүнгээр	Г
	3.2.Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн ажиллагаанд байнга хяналт тавьж, үзлэг хийх	Мэргэжил, арга зүйгээр хангасан байх	Г
	3.3.Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар ажилтан ажилчдад заавар зөвлөгөө өгөх		Г
	3.4.Барилга байгууламжийн бүх төрлийн цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг бэхлэх, тогтоох хэрэгслийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх, цахилгааны байгууламжуудын хэвийн найдвартай ажиллагааг хангах	Цахилгааны ажлыг заавар, технологийн дагуу чанартай хийх	Г
	3.5.Засвар үйлчилгээний ажлын үед болон газар ухах үед доогуур явж байгаа цахилгааны кабель утсуудыг тандуулах, таслахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	Гэмтэл, осолгүй ажиллах	Г
	3.6.Зарим тохиолдолд өндөр хүчдэлтэй ажиллах		Г
	3.7.Ашиглалтанд орох үед тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, нэг бүрчлэн үзлэг хийж хүлээн авах, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах	Аюулгүй байдлыг бүрдүүлж, эрсдлээс сэргийлж ажиллах	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрүүд, стандартуудыг мөрдөж ажиллах	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байх	Г
	4.2.Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа	Дүрэм журмын хүрээнд зөрчилгүй	Г

	мөрдлөг болгох	ажилласан байх	
	4.3.Ажлын байрны ерөнхий шаардлагыг хангахын тулд боловсрол, ур чадвараа дээшлүүлж, ажлынхаа бүтээмжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, санаачлагатай ажиллах	Санаачлагатай, хариуцлагатай ажилласан байдал	Г
	4.4.Цаг үеийн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай, бүрэн биелүүлж, үр дүнг тайлагнах	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байдал	Г
	4.5.Байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа сургалт, олон нийтийн арга хэмжээ, цэвэрлэгээ үйлчилгээний ажил, мэдээллийн цагт бүрэн хамрагдах	Оролцооны хувиар	Г


III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		Бүрэн дунд болон түүнээс дээш
Мэргэжил		Цахилгаанчин
Мэргэшил		Мэргэжлийн үнэмлэх, зэрэгтэй
Туршлага		2-оос дээш жил ажилласан
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Тулгамдсан асуудлыг зөв тодорхойлох -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах
	Асуудал шийдвэрлэх	-Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэнд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх
	Бусад	-Техникийн өргөн мэдлэгтэй, хурдан шаламгай, бүтээлч сэтгэлгээтэй -Ажигч гярхай, орон зайн баримжаа, харааны мэдрэмж сайтай -Кирилл болон монгол бичгийн дүрэм, бичиг, ярианы чадвартай

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: - Шуурхай үйлчилгээний албаны дарга, Ахлах мэргэжилтэн	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект -УБЗАА -Шуурхай удирдлагын цахим төв -Дүүргүүдийн цахилгаан түгээх ХҮТ -Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга  (Гарын үсэг) Х.Цогцэцэг (эцэг/эхийн нэр, өөрийн нэр)	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
Албан тушаал: Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	

 (Гарын үсэг) Б.Нарангэрэл (эцэг/эхийн нэр, өөрийн нэр) 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ Шийдвэрийн огноо: 2022 оны 03 дугаар сарын 28 Дугаар: А/23	
(Тамга/тэмдэг) ДАРГА 	 Б.МӨНХЦЭЦЭГ (Гарын үсэг) (эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр) 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр